



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 27

Номгон

Хуралдааны дэг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.14 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн II хуралдаанаас ТОГТООХ нь:


1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгийг хавсралтаар баталсугай.

2. Хуралдааны дэгийг чанд мөрдөж ажиллахыг хурлын нийт төлөөлөгчдөд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Ц.Отгонбаяр/-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 6 дахь удаагийн сонгуулийн II хуралдаанаар баталсан 2/1 тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



11602

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2016 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн II  
хуралдааны 2/1 тогтоолын хавсралт



## БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ДЭГ

**Нийтлэг үндэслэл:** Орон нутгийнхаа бие даасан байдлын болон иргэдийнхээ нийтлэг эрх ашгийн илэрхийлэл балсон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймгийн сонгуулийн эрх бүхий иргэдээс сонгогдож байгуулагддаг, Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтад хуулиар харьяалуулснаас бусад нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй, Үндсэн хуулийн статустай, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага мөн.

**Зорилго:** Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ энэхүү дэгийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгоно.

### Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан

1.1.1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

1.1.2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан нь анхдугаар, ээлжит, ээлжит бус, хүндэтгэлийн гэсэн хэлбэртэй байна.

#### 1.Хуралдааны үндсэн зарчим

1.1.3.Хуралдаан нь хууль дээдлэх, иргэд, орон нутгийн нийтлэг эрх ашиг, үндэсний эв нэгдлийг эрхэмлэх, ардчилсан, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлыг хангах, аливаа асуудлыг олон ургальч үзлийн үндсэн дээр чөлөөтэй хэлэлцэх зарчмыг баримтлан, цөөнхийн саналыг хүндэтгэн сонсож асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

1.1.4.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь бүрэн эрхээ хуралдаан, Тэргүүлэгчид, хороо, нам, эвслийн бүлэг болон зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.

1.1.5.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч хуралдааныг товлон зарласан цагт хүрэлцэн ирэх үүрэгтэй.

1.1.6.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаан, хороо, нам эвслийн бүлгийн хурал нь тус бүрийнх нь бүрэлдэхүүнд хамрагддаг нийт төлөөлөгчдийн олонхи нь хүрэлцэн ирсэн бол хүчинтэйд тооцно.



## 2.Хуралдааны төв, ирц

1.2.1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааныг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид хуралдааны бэлтгэл хангах шаардлагыг харгалзан 15-аас доошгүй хоногийн өмнө товлон зарлана.

1.2.2.Зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд Хурлын даргын саналыг үндэслэн хуралдааны товлосон хугацааг Тэргүүлэгчид өөрчлөн тогтоож болно.

1.2.3.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд ирэх боломжгүй бол Хурлын даргад урьдчилан мэдэгдэж чөлөө авна.

1.2.4.Хуралдааны дарга нам, эвслийн бүлгийн саналаар хуралдааныг түр завсарлуулж болно. Түр завсарлах хугацааг тухай бүр тогтооно.

1.2.5.Хуралдаанд хүрэлцэн ирээгүй төлөөлөгч өвчтэй байсан буусу өвчтэй хүн асарсан, гадаад, дотоодод томилолтоор явсан, түүнчлэн бусад хурал, семинарт зайлшгүй оролцох шаардлагатай бол хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзэх бөгөөд эдгээр шалтгаан байхгүй бол хуралдаан тасалсанд тооцно.

1.2.6.Хуралдааныг 18<sup>00</sup> цагаас хойш үргэлжлүүлэн хуралдуулах асуудлыг төлөөлөгчдийн олонхийн саналаар тухай бүр шийдвэрлэнэ.

## 3.Хуралдаан зохион байгуулах

1.3.1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэр, аймгийн Засаг даргын санаачилгаар ээлжит бус хуралдааныг шаардлагатай үед зарлан хуралдуулж болно.

1.3.2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс тусгайлсан шийдвэр гаргаагүй бол аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан явуулах албан ёсны байр нь аймгийн Нутгийн удирдлагын ордны хурлын танхим байна.

1.3.3.Шаардлагатай тохиолдолд нүүдлийн хуралдаан хийж болно.

1.3.4.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанд Тэргүүлэгчид, хороо, төлөөлөгч, аймгийн Засаг дарга асуудал санаачлан оруулах эрхтэй бөгөөд асуудал санаачилсан субъект хуралдаанд асуудал оруулах санал, түүнийг хэлэлцүүлэх шаардлага, үндэслэл, холбогдох тооцоо судалгаа, танилцуулга, хуралдаанаас гаргах тогтоол шийдвэрийн төслийн хамт аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлнэ.

1.3.5.Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх аймгийн иргэдийн нийтлэг эрх ашигтай холбоотой асуудлыг иргэдээр хэлэлцүүлсэн байна.

1.3.6.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан зарласан тухай бүр хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэн баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

1.3.7. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлын хамрах хүрээ, гаргах шийдвэрийг оновчтой болгох зорилгоор хуралдааны бэлтгэл ажлын явцад тодорхой чиглэлээр холбогдох ажил зохион байгуулж дүнг хурлын хуралдаанд тайлагнаж болно.

1.3.8. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан зарласан тухай шийдвэр батлагдсанаас хойш аймгийн Засаг дарга, төлөөлөгчид 3 хоногийн дотор, нийт байгууллага, албан тушаалтан, иргэдэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр 7 хоногийн дотор зарлан мэдээнэ.

1.3.9. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг холбогдох хороо авч үзэж, түүний мөрөөр үзлэг шалгалт хийх, ажил байдалтай танилцах арга хэмжээ авч шаардлагатай гэж үзвэл хурлын хуралдаанд хорооны илтгэл, хавсралт илтгэлийг оруулж хэлэлцүүлнэ.

1.3.10. Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалтай холбогдон байгууллага, албан тушаалтад өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанц ирүүлнэ.

1.3.11. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, бэлтгэл хангасан дүн, хэлэлцэх асуудлын талаар Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж зөвшөөрсний үндсэн дээр хурльн хуралдаанд оруулж хэлэлцүүлнэ.

1.3.12. Хуралдааны хугацаа болон хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлын материалыг төлөөлөгчдөд 3-аас доошгүй хоногийн өмнө электрон шуудангаар хүргүүлж, утсаар мэдэгдэнэ. Холбогдохгүй тохиолдолд утсанд мэдээлэп үлдээнэ.

1.3.13. Тэргүүлэгчдийн хуралдаанаар хуралдаанд оруулж хэлэлцүүлэх илтгэл, илтгэгчийг албан ёсоор томилно.

1.3.14. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд урилгаар оролцох хүмүүсийн нэрийг ажлын албанаас гаргаж Хурлын даргаар батлуулан хуралдаанд урьж оролцуулна.

1.3.15. Хэлэлцэх асуудлын ач холбогдлыг харгалzan зарим тодорхой асуудлын төслийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчлах, иргэний танхимаар хэлэлцүүлэх, иргэдийн дунд санал асуулга явуулах зэрэг хэлбэрээр явуулж, иргэдийн санал авах ажлыг зохион байгуулна.

1.3.16. Хуралдаан бүрийн эхэнд төлөөлөгчдийн ирцийг албан ёсоор бүртгэж ирцийн байдгыг танилцуулсаны үндсэн дээр хуралдааны ажиллагааг нээнэ.

1.3.17. Хуралдаан дээр төлөөлөгч асуудлыг шийдвэрлэхэд “дэмжсэн”, “татгалзсан” гэсэн 2 саналын аль нэгийг өгнө.

1.3.18. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч хурлын хуралдаанд оролцохдоо хуралдааны дэгийг сахих үүрэгтэй бөгөөд хуралдаан эхлэхээс өмнө суудлаа зээлсэн байна.

1.3.19. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан мэргэжлийн байгууллага, хүмүүсийг татан оролцуулж болно,

1.3.20. Хурлын хуралдаан ил тод, нээлттэй байдлаар явагдах бөгөөд иргэд, зочид төлөөлөгчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан зохих журмын дагуу байлцаж болно. Энэ асуудлыг тухай бүр Хурлын даргын шийдвэрээр ажлын алба зохицуулна.

1.3.21. Аймгийн иргэдийн Төлэөлөгчдийн Хурлын хуралдааныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулж болно.

1.3.22. Хурлын хуралдааныг нээлттэй явуулна. Хэлэлцэж байгаа зарим нэгэн тодорхой асуудлыг шаардлагатай гэж үзвэл төлөөлөгчдийн олонхийн санаалаар нууцын горимоор хаалттай явуулж болно.

1.3.23. Хуралдаанд тухайн хэлэлцэж байгаа асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, холбогдох мэргэжилтэн, албан тушаалтууд хуралд оролцож болох бөгөөд эдгээр бүрэлдэхүүнийг хуралдаанд асуудал оруулагч ажлын албатай зөвшилцэн зохион байгуулна.

1.3.24. Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гарах шийдвэрийн төслийг эцэслэн боловсруулах зорилгоор 3-5 хүний бүрэлдэхүүнтэй тогтоол шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулна.

#### 1.4. Хуралдаанд уг хэлэх, санал дүгнэлт гаргах, асуулт, тавих журам

Төлөөлөгч хуралдаан дээр уг хэлж байр сууриа илэрхийлэх, санал дүгнэлт гаргах, тайлбар хийхэд /цаашид “уг хэлэх” гэх/ дараах журмыг баримтална.

1.4.1. Уг хэлэх, асуулт асуухаа урьдчилан мэдэгдэн дараалалд орж хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авах.

1.4.2. Уг хэлэх, асуулт асуухдаа сонгогдсон тойргийн дугаар, өөрийн нэрээ хэлэх

1.4.3. Тогтоосон хугацаанд уг хэлэх, асуулт асуух, энэхүү эрхээ бусдад шилжүүлэхгүй байх

1.4.4. Хуралдаан даргалагч зөвшөөрөл өгөөгүй байхад уг хэлэх, асуулт асуух, энэхүү эрхээ эдлэхдээ бүдүүлэг уг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, басамжлах, яриаг нь таслах, өмнөөс нь уг хэлэх, өөрийн саналыг дэмжүүлэх буюу бусдын саналыг үгүйсгэх зорилгоор шахалт үзүүлэх, хүч хэрэглэх зэрэг ёс зүйд үл нийцэх үйлдэл гаргахгүй байх

1.4.5. Хуралдааны шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэхэд санал хураалтад оролцож байх

1.4.6. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан уг хэлэх хугацаа эхний удаа 5 хүртэл минут, дараагийн удаа 3 хүртэл минут байна.

1.4.7. Асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байна.

1.4.8. Төлөөлөгчийн асуултад хариулах хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 2 минутаас илүүгүй байна.

1.4.9. Хуралдаанд асуудал хэлэлцэхэд зөвхөн тухайн асуудал оруулж байгаа хүн хариу тайлбар хийнэ. Тухайн асуудал боловсруулахад оролцсон албан тушаалтан, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон, түүнчлэн хэлэлцэгдэж буй асуудалтай холбогдон хуралдаанд сролцож байгаа хүмүүс хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр тайлбар хийж, асуултад хариулж болно.

1.4.10. Төлөөлөгч тодорхой асуудлын хэлэлцүүлгийн явцад гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалгах буюу хэлэлцүүлгийн явцад татан авч болно.

#### 1.5. Хуралдаанд илтгэл, танилцуулга хийх

Хуралдаанд тухайн асуудал хариуцан оруулж байгаа албан тушаалтан илтгэл танилцуулга хийнэ. Үүнд:

1.5.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагаас эрхлэн оруулж байгаа асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Тэргүүлэгч, хорооны дарга, төлөөлөгч, ажлын албаны дарга

1.5.2. Аймгийн Засаг даргаас эрхлэн оруулж байгаа асуудлыг аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтсийн дарга нар

1.5.3. Засаг даргын дэргэдэх агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын үйл ажиллагаатай холбогдсон илтгэл, танилцуулгыг тухайн байгууллагын дарга, түүний эзгүйд орлогч нь

1.5.4. Хэлэлцэж буй асуудалтай хслбоотойгоор тухайн байгууллагын дарга, эрхлэгч, мэргэжилтнүүд хуралдаанд оролцоно.

#### 1.6. Санал хураалт явуулах

1.6.1. Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлыг ил болон нууц санал хураалтаар шийдвэрлэж болно.

1.6.2. Ил санал хураалтыг гар өргөж, нууц санал хураалтыг санал хураах хуудсаар авна.

1.6.3. Санал хураах хуудас ашиглан нууц санал хураалт явуулах бол төлөөлөгчдөөс бүрдсэн тооллогын комисс байгуулж ажиллуулна.

1.6.4. Санал хураалт явуулах үед төлөөлөгч санал өгөх эрхээ зөвхөн өөрөө зэдэлнэ.

1.6.5. Төлөөлөгч шийдвэр гаргах асуудлаар өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хувьд ашиг сонирхлын зэрчилтэй тэж үзвэл санал хураалтад оролцохоос сайн дураар татгалзах бөгөөд энэ тухайгаа хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэнэ.

1.6.6. Энэ журмын 1.6.5-д засны дагуу төлөөлөгч санал хураалтад оролцохоос татгалзсан бол түүнийг тухайн санал хураалтын ирцэд оруулахгүй.

1.6.7. Санал хураалтаар зарчмын зэрүүтэй санал дэмжигдснээр төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай бол түүнийг багцлан нэг санал хураалт явуулна.

1.6.8. Илээр санал хураахад ажлын албанаас төлөөлөгчдийн саналын тоог тоолж, тэмдэглэлд тусган бичнэ.

#### 1.7. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаан

Анхдугаар хуралдаанаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу зохион байгуулалтын асуудал хэлэлцэх бөгөөд нээлтийн ажиллагааг дараах журмаар зохион байгуулна.

1.7.1. Шинээр сонгогдсон төлөөлөгчдийн насаар хамгийн ахмад төлөөлөгч хуралдааныг нээж даргална.

1.7.2. Орон нутгийн ээлжит сонгуулийн дүн, сонгогдсон төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай илтгэлийг Сонгуулийн хорооны дарга тавих бөгөөд илтгэлтэй холбогдуулан асуулт асууна.

1.7.3. Сонгуулийн хорооны илтгэл, асуулт, хариултын дараа хуралдаан даргалагч төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай тогтоолыг батлуулна.

1.7.4. Төлөөлөгчдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсний дараа Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг сонгоно.

1.7.5. Сонгуулийн дүнгээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд аль ч нам эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл нь бусад нам, эвсэлтэй зөвшилцэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад нэр дэвшүүлнэ.

1.7.6. Шинээр сонгогдсон Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга төлөөлөгчдөд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн үнэмлэх, энгэрийн тэмдэг гардуулж амжилт хүснэ.

1.7.7. Шинээр сонгогдсон εймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга хуралдааныг үргэлжлүүлэн удирдан .

#### 1.8. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаан

1.8.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа зарлан хуралдуулна.

1.8.2. Ээлжит хуралдааныг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар товлон зарлаж, бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг батална.

#### 1.9. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдаан

1.9.1. Ажлын зайлшгүй шаардлагыг харгалзан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдааны чөлөө цэгт ээлжит бус хуралдаан зарлан хуралдуулж болно.

1.9.2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар ээлжит бус хуралдааныг товлон зарпана.

**1.10. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хүндэтгэлийн хуралдаан**

1.10.1. Монгол Улсын болон аймгийн түүхэн хөгжилтэй салшгүй холбоотой томоохон ой, бусад үйл явдлуудыг тэмдэглэхтэй холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хүндэтгэлийн хуралдаан зарлан хуралдуулж болно.

1.10.2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид Хүндэтгэлийн хуралдаан хуралдуулах тухай тогтоол гаргана.

**1.11. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч сонгох**

1.11.1. Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь заалтын дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийг сонгоно.

1.11.2. Шаардлагатай бол аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь нам, эвслийн бүлэгтэй зөвшилцэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийг сонгуулах санал оруулж болно.

1.11.3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаас Тэргүүлэгчээр сонгуулах төлөөлөгчдийн нэр дэвшүүлнэ.

1.11.4. Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид өөрийн болон бусад төлөөлөгчийн нэрийг дэвшүүлэх ажиллагаа явагдана.

1.11.5. Нэр дэвшигчдийн талгар нууц санал хураалт явуулж хамгийн олон санал авсан дарааллын дагуу тогтоосон тоонд багтсан нэр дэвшигчдийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчээр сонгогдсонд тооцож тогтоол гаргана.

1.11.6. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Тэргүүлэгч нарыг нэгдсэн жагсаалтад оруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийг сонгож байгуулсан тогтоол гаргана.

**1.12. Хуралдаан даргалагчийн эрх, үүрэг**

Хуралдааны үйл ажиллагааг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, түүний эзгүйд олонхийн саналаар аль нэг тэргүүлэгч гишүүн удирдана. Хуралдааны нарийн бичгийн даргыг тухай бүр сонгон ажиллуулна.

1.12.1. Хуралдааныг зохион байгуулах талаар хуралдаан даргалагч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

1.12.2. Хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хуралдааны дотоод журмыг батлуулж дэгийн биелэлтийг хангуулна.

1.12.3. Хуралдааныг товлосон цагт эхлүүлж, дэгийн дагуу зохион байгуулах

1.12.4. Саналаа ирүүлсэн дарааллыг баримтлан төлөөлөгчдөд асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл олгох.

1.12.5. Хэлэлцэж байгаа асууллаар асуулт, хариулт, санал дүгнэлт, санал хураалт явуулж дүн явцыг мэдээлж, эцсийн глийдвэрийн төслийг хэлэлцүүлж батлуулах.



1.12.6.Хэлэлцэж байгаа асуудлаар төлөөлөгчдийн гаргасан горимын саналыг сонсож, түүгээр санал хураалт явуулна. Горимын саналд хуралдаанаар асуудлыг хэлэлцэх журам, дарааллын талаар гаргасан саналыг горимын саналд тооцох бөгөөд түүгээр нэг удаа санал хураалт явуулна.

1.12.7.Төлөөлөгчид болон хуралдаанд оролцож байгаа урилгаар оролцогчдод хуралдааны үед танхимаас гарах зөвшөөрөл өлгөно.

1.12.8.Урилгаар болон хэлэлцэж байгаа асуудалтай холбогдон хуралдаанд оролцож байгаа хүмүүст төлөөлөг үйлийн асуултад хариулах, тайлбар хийх зөвшөөрөл өлгөно.

1.12.9.Хуралдааны шийдвэрийг хэлбэржүүлэх, ёсчлох ажлыг зохион байгуулна.

1.12.10.Ирц хүрэлцэхүйц байвал хүсэлт гаргасан хүндэтгэх шалтгаантай төлөөлөгчид чөлөө өгнө.

1.12.11.Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх

#### **Хоёр Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нам, эвслийн бүлэг байгуулах**

2.1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нам, эвслийн бүлэгтэй байж болно.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 5 ба түүнээс дээш тооны суудал авсан нам, эвсэл бүлэг байгуулах эрхтэй.

2.2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь олонх, цөөнхийн авсан суудлыг зөвхөн тухайн нам, эвслээс нэр дэвшин сонгогдсон төлөөлөгчийн тоогоор тодорхойлох бөгөөд үүнд бие даан нэр дэвшиж сонгогдсон төлөөлөгчийг оруулж тооцохгүй.

2.3.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 50 ба түүнээс дээшхувийн суудал авсан нам, эвслийг олонхи гэнэ.

2.4.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд суудал авсан нам, эвсэл нь бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдуугаар хуралдаанд уншин сонсож, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад өргөн мэдүүлэх бөгөөд ийнхүү өргөн мэдүүлснээр бүлэг байгуулагдсанд тооцно.

2.5.Намын бүлэг байгуулах асуудлаар аливаа хэлэлцүүлэг явуулахгүй.

2.6..Нам, эвслийн бүлэг нь хурлын хуралдаанаар хэлэлцэж буй тухайнасуудалтай холбогдуулан шаардлагатай үед хуралдаанаас 1 удаа завсарлага авч болно. Завсарлагын хугацаа 30 минутхүртэл байна.

2.7.Завсарлагын хугацааг сунгах шаардлагатай гэж үзвэл нэг удаа сунгаж болох бөгөөд тогтоосон хугацааг чанд баримтална.

2.8.Нам эвслийн бүлэг хуралдааны ажиллагаанд хүндэтгэлтэй хандана. Завсарлага авч тогтоосон хугацаанд хурлын хуралдаанд хүрэлцэн ирзэгүй тохиолдолд хурлын ирц хурвэл төлөөлөгчдийн олонхийн саналаар хуралдааныг үргэлжлүүлнэ.

2.9. Нам эвслийн бүлгээс хуралдааныг зөвшөөрөлгүй орхихыг хориглохбөгөөд хурлыг орхисон тохиолдолд эсрэг санал өгсөнд тооцно.

2.10. Нам эвслийн булэг нь дараах эрх, үүрэгтэй байна.

2.10.1. Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал, түүний дарааллын талаар Хурлын даргад байр сууриа илэрхийлэх, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах

2.10.2..Хурлын хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар бодлого, байр сууриа тодорхойлж санал дүгнэлт гаргаж хэлэлцүүлэх

2.10.3.Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах

2.10.4.Хорооны бүрэлдэхүүний талаар хурлын драгатай зөвшилцэх

2.10.5.Хурлын байгууллагын үйл ажиллагаанд бүлгийн гишүүдийг оролцуулах. Хуралдааны ирцийг хангах, Хуралдааны үеэр дэгийг чанд сахиулах

Гурав. Төлөөлөгчөөс асуулга тавих

3.1 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн асуулга нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх нэг үндсэн хэлбэр мөн.

3.2.Орон нутаг, нийгэм, иргэдийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзвэл уг асуудлаар Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга, агентлагийн дарга нарын байр суурийг тодруулах болон тодорхой үйл ажиллагаа явуулахыг шаардаж төлөөлөгчөөс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан дээр албан тушаалтад бичгээр хандсаныг асуулга гэнэ.

3.3.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь аймгийн Засаг дарга, орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга, Засаг даргын дэргэдэх агентлагийн дарга нарт асуулга тавих, түүний хариуг Тэргүүлэгчдийн болон Хурлын хуралдаанаас хэлэлцүүлэх эрхтэй.

3.4.Асуулга нь тухайн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх, хариуцах ажлын хурээнд багтсан байна.

3.5.Асуулга хүлээн авсан албан тушаалтан асуултын хариуг төлөөлөгчид 14 хоногийн дотор бичгээр өгнө.

3.6.Асуулга тавьсан төлөөлөгчийн хүсэлтээр түүний хариуг Тэргүүлэгчдийн болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.

3.7.Асуудал хариуцсан хороо буюу ажлын алба Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох тесөл боловсруулж Тэргүүлэгчдийн буюу хурлын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

3.8.Төлөөлөгч асуулгын хариуг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэг элцүүлэх саналаа хуралдаанаас 7 хоногийн өмнө аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад бичгээр ирүүлнэ.

3.9. Асуулгын хариуг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн эсвэл хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх товыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тогтоож, хариуцан хэлэлцүүлэх албан тушаалтад урьдчилан мэдэгдэнэ.

3.10. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн эсвэл Хурлын хуралдаан дээр асуулгад хариуцах хугацаа 7 минутаас илүүгүй, төлөөлөгчид асуулгын хариутай холбогдуулан асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй байна.

3.11. Асуулгад хариу өгсөний дараа асуулга тавьсан төлөөлөгч нэг удаа 5 минутаас илүүгүй хугацаанд уг хэлж болно.

3.12. Асуулгын хариуг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн эсвэл хурлын ээлжит хуралдааны хэлэлцэх асуудалд оруулж хэлэлцэнэ.

#### Дөрөв. Төлөөлөгчөөс асуулт тавих

4.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан дээр шууд болон бичгээр асуулт тавьж хариу авах эрхтэй.

4.2. Аймаг, орон нутгийн болон иргэдийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзвэл тодорхой нэг асуудлаар төлөөлөгч, Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтсийн дарга нар, Засаг даргын дэргэдэх агентлаг болон төрийн болон орон нутгийн өмчтэй байгууллагуудын дарга, эрхлэгчдэд бичгээр хандсаныг асуулт гэнэ.

4.3. Асуултын хариултыг төлөөлөгчид холбогдох ажилтан бичгээр өгөх бөгөөд хугацаа шаардагдах бол ажлын 3 хоногт багтаан өгнө. Асуултын хариулт нь бичгийн А4 хэмжээний 2 хуудаснаас илүүгүй байна.

4.4. Төлөөлөгч асуултын хариуг бичгээр авсаны дараа түүнийг хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх саналаа хорооны даргад бичгээр ирүүлнэ.

4.5. Хорооны дарга төлөөлөгчийн асуултын хариуг хорооны хурлаар хэлэлцүүлэх асуудлыг төлөөлөгчийн саналыг харгалзан хорооны гишүүдэд танилцуулж Хурал зарлана.

4.6. Хорооны хуралдаан дээр асуултын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд өгөх ба хорооны гишүүд 2 минутаас илүүгүй хугацаанд асуулт асууна.

4.7. Холбогдох албан тушаалтан асуултад хариулсаны дараа асуулт тавьсан төлөөлөгч 2 минутаас илүүгүй хугацаанд уг хэлэх, тавьсан асуулттайгаа холбоотой өөр асуулт асууна.

4.8. Асуултын хариултыг сонсох ажиллагааг олон нийтэд мэдээлнэ.

#### Тав. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

#### шийдвэрт тавьсан Засаг даргын хоригийг хэлэлцэх

5.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу аймгийн Засаг даргаас Хурлын шийдвэрт

бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт тавьсан хоригийг ажлын алба ирсэн бичгийн буртгэлд өдөр, цаг, минуттай нь тодорхой бүртгэсэн байна.

5.6. Хоригийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захирагаа, нутаг дэвсгэсийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

**Зургаа.Хуралдааны дэгийн хэрэгжилтэд  
хяналт тавих, өөрчлөлт оруулах**

6.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгт нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хурлын төлөөлөгчдийн олонхийн саналаар шийдвэрлэж болно.

6.2. Дэгийн хэрэгжилтэд хүрлын төлөөлөгчид, Хурпын дарга хяналт тавьж ажиллана.

**Долоо: Тэмдэглэл хөтлөх, ёсчилох**

7.1 Хуралдааны тэмдэглэлийг албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу хөтлөн бичиж, хэлэлцэж буй асуудлын тооноос хамаарч ажлын 3-5 хоногийн дотор Хурлын даргаар эцэслэн хянуулан баталгаажуулна.

7.2 Шаардлагатай тохиолдолд тэмдэглэлийг төлөөлөгчдөд хувилан өгч болно.

7.3 Төлөөлөгчид өөрсдийн гаргасан саналыг хуралдаанаас гарах шийдвэрийн төсөлд оруулахаар найруулга хийж бичгээр ажлын албанд өгч болно.

ооо



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 08 сарын 05 өдөр


Дугаар 2/2

Номгон

Хорооны тоо, бүрэлдэхүүн,  
ажиллах журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн II хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хянан шалгах чиг үүрэг бүхий 6 хороотой байхаар тогтох, хорооны бүрэлдэхүүн, эрхлэх асуудлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Хурлын хороодын ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Хороодын ажиллах журмыг хэрэгжүүлж, хурлын байгууллагын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангаж идэвх санаачилгатай ажиллахыг Хурлын хороодын дарга нарт даалгасугай.
4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 6 дахь удаагийн сонгуулийн II хуралдаанаар баталсан 2/3 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2016 оны 08 дугаар сарын 05-ны ээлжит II  
хуралдааны 2/2 дугаар тогтооны  
нэгдүгээр хавсралт

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН, ЭРХЛЭХ АСУУДАЛ**

№	Хурлын хороодын нэр	Хорооны бүрэлдэхүүн	Хороодын эрхлэх асуудал	
			3	4
1	2		<ul style="list-style-type: none"> <li>- Нийтийн салбарын бодлогын хэлтэс, агентлагууд</li> <li>- Хүн амын эруул мэнд</li> <li>- Хүн амын боловсрол</li> <li>- Хүн амын соёл, урлаг, спортын үйлчилгээний асуудал</li> <li>- Ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх</li> <li>- Ядуурлыг бууруулах, өрхийн амьжиргааг дээшшүүлэх</li> <li>-Өндөр настан, хүн амын эмзэг бүлгийн нийгмийн халамж үйлчилгээ</li> <li>-Хүүхэд, запуучууд болон эмэгтэйчүүдийн талаарх бодлого</li> <li>-Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт, нийгмийн даатгал, цалин тэтгэврийн асуудлууд</li> <li>-Үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, тайлант иргээд тавиулах</li> <li>-Төрийн бус байгууллага</li> <li>-Тухайн чиглэлээр хамтран ажиллах боломж бүхий олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагууд</li> <li>-Хэвлэл, мэдээллийн үйлчилгээг хөгжүүлж, нийтэд хүртээмжтэй болгох</li> <li>-Бусад холбогдох асуудлуул</li> </ul>	
2	3			

ХИММИНИЙ ХӨХЖЛЭЛИЙН ХОЛОХ

Санхүү, төсөв, зорилтуудын салбарын бодлогын хэлтэс энтидагууд  
Санхүү, төсөв, зорилтуудын салбарын бодлогын хэлтэс энтидагууд

Xэгжлийн ажлын  
специалистийн  
коопоо

- Санхүү, эдийн засгийн салбарын бодлогын хэлтэс энтидагууд
- Аймийн эдийн засгийн стратегийн асуудлууд
- Төсвийг зохицой хуваарилах, зардлыг хэмнэх
- Аж Уйлдвэр, барилга зам, таазэр холбоо, гадаад дотоод худалдаа, аялал жуулчлал хөгжүүлэх
- Орон нутгийн арилжааны банкны салбартай хамтран ажиллах хөгжүүлэх
- Статистик мэдээллийн боловсронгуй болгож, иргэдэд мэдээлэх, ашиглах
- Үндсэн чиглэл, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, зээл тусдамжийн

1. П.Рэнцэнпэлжээ
2. Б.Батбаяр
3. Б.Энхтувшин
4. Д.Ширмэн
5. Д.Мөнхсайхан

- Зах зээлийн эдийн засгийн бүтцийг хөгжүүлэх
- Аудитын болон санхүүгийн хяналт шалгалтын Мөрөөр зохиох ажил
- Төрийн болон орон нутгийн ёмч, ёмчийн хадгалалт, хамгаалалт, хувьчлал
- Ашигллагаагүй нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах, шинжлэх ухааны ололт, тэргүүний технологи нэвтрүүлэх
- Хөрөнгө оруулалтын таатай орчин бурдүүлэх, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх
- Төрийн бус байгууллага
- Тухайн чиглэлээр хамтран ажиллах боломж бүхий олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагууд
- Бусад холбогдох асуудлууд

- Хөдөө аж ахуйн салбарын бодлогын хэлтэс, агентлагууд
- Хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлого
- Орх, фермерийн аж ахуйг хөгжүүлэх
- Малын эрүүл мэнд, үржил селекцион ажлыг сайжруулах
- Газар тариалангийн үр ашгийг намэгдүүлэх бодлого
- Малчдын амьдралт ахуйг дээшшүүлэх зорилгоор бичиглээлд хамруулах
- Хүн амын хүчиний хангамж, чайзар эрүүл ахуйг сайжруулах бодлого
- Үйлдвэрлэл, чийгчилгээг хөгжүүлэх, татварын баазыг өргөжүүлэх бодлого
- Жижиг, дунд үйлдвэр, хоршоог хөгжүүлэх бодлого
- Тухайн чиглэлээр хамтран ажиллах боломж бүхий олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагууд
- Бусад холбогдох асуудлууд

1	2	3	4
- Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн асуудал эрхэлсэн хэлтэс агентлагууд	- Байгаль орчин, газрын харилцаа, аялал жуулчлалын талаар баримтлах бодлого	- Газар зээмшилт, ашиглалт, хамгаалалт	- Ойн нөөцийг зүй зохицой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх - Усны нөөцийг зүй зохицой ашиглах, хамгаалах

- Агаарын бодирдлыг бууруулах
- АН амьтын агуулурын нөөцийг зүй зохицой ашиглах, биологийн төрөл зүйлийг хамгаалах
- Зарим газар нутгийг аймгийн тусгай хамгаалалтанд авах, чөлөөлөх тухай бодлого боловсруулах
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
- Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх
- Аймгийн Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Байгаль орчинд хоргуй, хаягдалгүй технологи нэвтрүүлэх
- Хог хаягдлыг бууруулах, зайнпуулах, боловсруулах, устахаас
- Химиин хортой болон цацраг идэвхт бодисын ашиглалтад хяналт тавих
- Байгаль орчинд хамгаалахад нутгийн иргэдийн оролцоог дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах олон нийтийн зөвлөлийн ажил
- Байгалийн баялагийг үр өгөөжтэй ашиглах бодлого
- Ашигт малтмалын олборполт, хайгуул явуулж буй аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг боловсруулах
- Төрийн бус байгууллага
- Тухайн чиглэлээр хамтран ажиллах боломж бүхий олон улсын төсөл
- Бусад холбоодох асуудлууд

Банкны төслийн хувь  
Банкны төслийн хувь

1	2	3	4
1. М.Мөнхбат 2. Ц.Төмөрбаатар 3. Т.Отгонбаатар 4. Д.Жаргалсайхан 5. Г.Батжаргал 6. Ж.Хүрэлбаатар 7. Э.Энхбат	3	<p>-Үйлдвэрлэл, дэд бүтэц, гадаад харилцааны асуудал эрхэлсэн</p> <p>агентлагууд</p> <ul style="list-style-type: none"> <li>- Аймгийн дэд бүтцийг сайжруулах болдого боловсруулах</li> <li>- Хот байгуулалт, архитектур төлөвлөлт, стратегийн бодлого</li> <li>- Дэд бүтцийн ашиглалтыг сайжруулах болдого</li> <li>- Сумдын дэд бүтэц, төлөвлөлтийн болдого</li> <li>- Хүн амын ахуйн Үйлчилгээ /орон сууц, ундны ус, хагаант, цахилгаан, халуун ус, хог, бохир ус г.м./</li> <li>- Төрийн бус байгууллага</li> <li>- Тухайн чиглэлээр хамтран ажиллах боломж бүхий олон улсын төсөл</li> </ul> <p>хөтөлбөрийн байгууллагууд</p> <ul style="list-style-type: none"> <li>- Аймгийн гадаад харилцааг өргөжүүлэх болдого</li> <li>- Нутгийн өөрийн удирдах байгууллагын гадаад харилцааг хөгжүүлэх</li> <li>- Бусад холбогдох асуудлууд</li> </ul>	<p>-Холбогдох хэлтэс, агентлагууд</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төр, засгийн хууль тогтоомж, аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хянгаалт тавих, сурталчлах</li> <li>- Шийдвэр гаргах уйл ажиллагаанд иргэдийн орлогцоог хангах</li> <li>- Гэмт хөргээс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журмыг бэхжүүлэх, архидан соттуурахтай 1 эмцэх</li> <li>- Цагдаа, шүүх, прокурорын байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд -Хууль, тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах</li> <li>- Иргэдийн хууль ёсны эрхийг хамгаалах, эрхзүйн мэдлэг, хүмүүжлийг дээшшуулэх</li> <li>- Гамшигаас хамгаалах тухай, гамшигийн эмзээг байдал, эрсдлийн үнэлгээ хийх аргачлал журмын хэрэгжилт, гамшигийн үед ажиллах бэлтгэл, бэлэн байдлын өнөөгийн тувшин цаашид авах арга хэмжээний тухай</li> <li>- Үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, тайланг иргэдэд тавиулах</li> </ul> <ul style="list-style-type: none"> <li>- Иргэдийн өргөдөл гомдолтыг шийдвэрлэж буй байдал, түүний хэрэгжилт</li> <li>- Төрийн бус байгууллага, шашны байгууллага</li> <li>- Хэвлэл, мэдээллийн Үйлчилгээг хөгжүүлж, нийтэд хүртээмжтэй болгох</li> <li>-Бусад холбогдох асуудлууд</li> </ul>
5	6	<p>ХүнАБАРН, АЗАГҮҮРЧИ, РАГЗАА</p> <p>ХүнАБАРН, АЗАГҮҮРЧИ, РАГЗАА</p>	<p>ROMAIPH XOPOO</p> <p>ХҮҮРҮҮРСДХ 3ЫН, НИРХИНН ОПОРНУУ, ЕРГЭДЛ</p>

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2016 оны 08 дугаар сарын 05-ны ээлжит  
бус II хуралдааны 2/2 дугаар тогтоолын  
хоёрдугаар хавсралт

## АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХОРООДЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Зорилго

1.1 Аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий хороо байгуулах, түүний ажлын зохион байгуулалт, Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангахад энэхүү журмын зорилго оршино.

### Хоёр. Хурлын хорооны ажлын зохион байгуулалт

2.1 Хурлын хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

2.2 Хурлын хороо улирал бүрийн эхний сарын 15-ны дотор хуралдана.

2.3. Хурлын хорооны нийт гишүүний олонхи нь хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.4. Хурлын хорооны хуралдааныг аймгийн ИТХ-ын хуралдааны чөлөө цагт зохион байгуулж гаргасан шийдвэрийг хурлын хуралдаанд өргөн барина.

2.5. Хурлын хороо нь эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэн дүгнэлт, зөвлөмж, тогтоолын аль нэгийг гаргаж болно.

2.6 Хурлын хороодын үйл ажиллагааг хорооны даргаас өгсөн чиглэлийн дагуу ажлын албаны хороодын ажил хариуцсан мэргэжилтэн хариуцан зохион байгуулж, хуралдааны тэмдэглэлийг хөтлөнө.

2.7. Хурлын хорооны хуралдааны тэмдэглэлд явцыг нэг бүрчлэн бичиж тэмдэглэнэ.

## **Гурав. Хурлын хорооны бүрэлдэхүүн**

3.1 Хурлын хороо нь 6-7 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй байна.

3.2. Хурлын хороодын үйл ажиллагааг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу ~~аймгийн ИТХ-аас~~ байгуулсан хорооны бүрэлдэхүүнд орсон төлөөлөгчдийн дотроос ~~сонгасон Тэргүүлэгч~~ удирдана.

3.3 Хурлын хорооны дарга хорооныхоо ажлыг удирдаж хуралдааныг даргална.

## **Дөрөв. Хурлын хорооны даргын чиг үүрэг**

4.1. Хурлын хорооны дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1. Хурлын хорооны хуралдааны бэлтгэлийг хангаж зохион байгуулах;

4.1.2. Хурлын хорооны хуралдааныг удирдах;

4.1.3. Хурлын хорооны нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцах;

## **Тав. Хурлын хороодын үйл ажиллагааны чиглэл**

5.1 Хурлын хороод нь аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлийг үндэслэн ажлаа жил улирлаар төлөвлөн ажиллана.

5.2 Хурлын хороод нь аймгийн ИТХ-аар батлах тогтоол, хөтөлбөр, дүрэм, журмыг хэлэлцэн бодлогыг сонвчтой тодорхойлох, иргэдийн санал бодолд нийцсэн шийдвэр гаргахад анхаарч ажиллана.

5.3 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр оруулж буй өөрийн хариуцсан ажлын чиглэлтэй холбоотой асуудлыг хорооны хурлаар урьдчилан хэлэлцэж санал дүгнэлт гарган хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлнэ.

5.4 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт гаргана.

5.5 Хариуцсан ажлын тодорхой чиглэлүүдээр хурлын хорооны нэрэмжит узлэгүүдийг зохион байгуулж дүнг Хурал, Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулна.

5.6 Зайлшгүй шаардлагатай, тулгамдсан асуудлыг судлан боловсруулж, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, саналын хамт Тэргүүлэгчдэд өргөн мэдүүлж, шийдвэр гаргуулж ажиллана.

5.7 Хурлын хорооны хурлаар тодорхой байгууллага, албан тушаалтны мэдээлэл, сонсголыг хэлэлцэж болно.

5.8 Хурлын хорооны хурлаар ажлын төлөвлөгөөгөө хэлэлцэн баталж гишигдээ тодорхой ажил нүрэг хариуцуулж, биелэлтийг нь тооцон ажиллана.

5.9 Хурлын хороод ажлынхаа явц, ололт дутагдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчилж, иргэдтэй байнгын харилцаатай ажиллана.

о О о